

ЕВРОП ДАХЬ ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭ

Б.Оюунцэцэг*

Descriptions and Indicators of Citizenship Education in European Countries

The Council of Europe proclaimed the year 2005 European Year Citizenship through Education and related meetings or programs regarding Citizenship Education have been held and realized throughout the European countries. "Citizenship" has been the hot topic upon the approval of "Citizenship of the Union", which authorize citizens to travel, work or participate in the local political activities liberally in European Union Countries, by the Maastricht Treaty in 1993. This paper focuses on the Education for Democratic Citizenship, Lisbon strategies and how its indicators or benchmarks are developed, as well as intention to realize "Active citizenship education" in order to develop "Civic competences". Beyond it, the concept of "Active citizenship" is remarkable which will give considerable contribution to strengthening social cohesion by enabling citizens to participate actively in the political and public activities and to learn how to work with other people on the basis of interactions; and even by developing individuals to live and work in Knowledge-based economy of Globalization.

Түлхүүр үг: ардчилсан иргэний боловсрол, нийгмийн эв нэгдэл, иргэний чадвар, боловсролын үнэлгээ

1. Удиртгал

Европын Комисс (Council of Europe)-ийн санаачлагаар 2005 оныг "Боловсролд тулгуурласан иргэн-Европын он" (European Year Citizenship through Education) болгон зарлаж, Европын бүх газар нутагт иргэний боловсролын талаар хурал зөвлөгөөн, хөтөлбөр хэрэгжих болсон байна. 1993 оны Маастрихтын гэрээгээр Европын холбооны улсууд хоорондоо чөлөөтэй зорчих, хөдөлмөрлөх, орон нутгийн улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхийг олгосон "Европын иргэний эрх" батлагдсанаар иргэншлийн асуудал их яригдах болсон юм. Түүнчлэн Европын холбоо өргөжин, даяарчлал идэвхжиж, хил дамнан шилжин суурьших цагаачид болон энгийн хүмүүсийн хөдөлгөөн ихэссэнтэй уялдан ардчилал, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэх шаардлага гарч, Европын улс орнууд иргэний боловсролд түлхүү анхаарч, хамтын төсөл хэрэгжүүлэх болжээ. Уг өгүүлэлд Европын холбооны иргэний боловсролын туршлага, онцлогийн талаар танилцуулахыг зорилоо.

2. Европын комисс болон иргэний боловсролын үзэл санаа

2010 оны байдлаар Европын комисст Европын холбооноос илүү 46 улс гишүүнээр элсээд байна. Европын комисс 1997 онд "ардчилсан иргэний боловсрол (Education for Democratic Citizenship)" хэрэгжүүлэх шийдвэр гаргаж, 2002 онд гишүүн улсуудад үүнийг хэрэгжүүлэхийг санал болгосон юм. Үүний

*Б.Оюунцэцэг - Нихон их сургуулийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор (Ph.D)

цаана нэлээд хэдэн шалтгаан бий. Тухайлбал Берлины хана нурж, хүйтэн дайн төгсгөл болсонтой уялдан Зүүн европын улсуудад ардчилал, иргэний боловсролыг хэрэгжүүлэх шаардлага гарсан. Үүний дагуу “ардчилсан иргэний боловсрол”-ын мэргэжилтэний сүлжээ байгуулагдаж, иргэний боловсролын утга, ач холбогдолыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн талаар хэлэлцэхийн зэрэгцээ нэлээд олон ном товхимол хэвлэн гаргажээ. Түүнчлэн “ардчилсан иргэний боловсрол”-ыг амжилттай хэрэгжүүлсэн төслийг шагнаж урамшуулах зэргээр иргэний боловсролыг идэвхижүүлэхэд чиглэсэн олон төрлийн арга хэмжээ хэрэгжүүлж иржээ. Ийнхүү Европын комисс гишүүн орнуудаа иргэний боловсролд уриалаад зогсохгүй түүнийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор НҮБ зэрэг олон улсын байгууллага болон олон нийтийн сайн дурын байгууллагатай эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг хэрэгжүүлэх болсон байна. Эдгээр төсөл, хамтын ажиллагаан дахь ардчилсан иргэний боловсролын зорилгыг Durr Karlheinz (2000)¹ дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

- ардчилсан иргэний нийгэмд идэвхитэй оролцоход шаардлагатай мэдээлэл, ур чадвар, мэдлэг эзэмшүүлэх

- харилцан ярилцах, мэтгэлцэх, асуудлыг шийдвэрлэх, санал нэгдэх, бусадтай холбоо харилцаа тогтоох, харилцан үйлчлэх боломж олгох

- нийгмийн харилцаан дахь эрх, үүрэг, үнэт зүйл, ёс зүйн хэм хэмжээний талаар мэдлэг, ойлголт сэдэл өгөх (awareness)

Улмаар “ардчилсан иргэний боловсрол” нь хүний эрх, эрх чөлөө, хууль, журам зэрэг нийтлэг үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, түүний үндэс суурь болох ардчилсан үзэл, соёлыг хөгжүүлж, бэхжүүлэх зорилготой. Нийгмийн харилцаанд шийдвэр гаргах үйл явцад идэвхи санаачлагатайгаар оролцож, хариуллага даах чадвартай байхуйцаар хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийг дэмжихэд чиглэсэн олон нийтийн байгууллагаас гаргасан санал санаачлагыг дэмжсэн (bottom up) бүхий л үйл практик үйл ажиллагааг хэлнэгэж тодорхойлсон байдаг. Энэ мэтчилэн ардчилсан иргэний боловсрол нь өргөн цар хүрээний үйл ажиллагааг хамарч, нэг хичээлийн хүрээнд бус нийгмийн ухаан, хүний эрхийн боловсрол, ёс суртахууны боловсрол, эрх зүйн боловсрол зэрэг олон хичээлийн хүрээнд залгамж холбоотойгоор хичээлээс гадуурх сургалтын ажил, сургууль болон бус нутгийн хамтын ажиллагаа зэрэг төрөл бүрийн үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн үйл хэрэгт идэвхитэй оролцож, түгээн байгуулж, бусадтай зөв харилцах иргэнийг бэлтгэхэд анхаарах болжээ.

Иргэний боловсролыг бага, дунд сургуулийн хөтөлбөрт тусгах арга хэлбэр нь улс орон болгонд харилцан адилгүй байдаг. Тухайлбал Англи улсад иргэний боловсролыг тусгай бие даасан хичээлийн хүрээнд хэрэгжүүлдэг бол Австри зэрэг улсад саяхныг хүртэл тусгайлсан хичээлгүй, нийт хичээлийн “үндсэн агуулга”-д багтаасан байдаг. Мөн Европын комиссоос санал болгосон “ардчилсан иргэний боловсрол”-ын гишүүн орнуудад үзүүлэх нөлөө харилцан адилгүй байна. Зүүн Европын орнууд болон иргэний боловсролыг шинээр хэрэгжүүлэх шаардлагатай улс орнууд “ардчилсан иргэний боловсрол”-ыг идэвхитэй хэрэгжүүлж байгаа бол Герман зэрэг улс төрийн боловсрол

(Politische Bildung)-д суурилсан уламжлалт хичээлтэй орнуудад “ардчилсан иргэний боловсрол”-ыг хэрхэн уялдуулах талаар хэлэлцэх шаардлага гардаг. Иймд иргэний боловсролын мэргэжилтэний сүлжээ байгуулах, түүгээр дамжуулан мэдээлэл, туршлага солилцох, амжилттай хэрэгжсэн практик жишээг танилцуулж, дэлгэрүүлэх зэргээр иргэний боловсролын зорилго, тодорхойлолтыг хэлэлцэж нэгдсэн хөтөлбөр боловсруулах нь Европт иргэний боловсролыг амжилттай хэрэгжүүлэх үндэс суурь нь юм.

3. Иргэний боловсролын зорилго

Европын комисс (Council of Europe) “ардчилсан иргэний боловсрол”-ыг санал болгосноос хойш 3 жилийн дараа Европын холбоо 2000 онд Лисбонд болсон Европын зөвлөл (European Council)-ийн хурлаар ажлын байрыг нэмэгдүүлж, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэхийн хамт тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангах мэдлэгт суурилсан эдийн засгийн бүс байгуулах тухай “Лисбоны стратеги”-ийг боловсруулсан. Улмаар “дэлхийд өрсөлдөх чадвараар дээгүүр орох, өргөн цар хүрээний мэдлэгт суурилсан эдийн засгийн бүс”-ийг бүтээн байгуулахад боловсрол чухал үүрэг гүйцэтгэх талаар зааж, дараагийн 10 жилд хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн (Education & Training 2010). Тухайлбал 2010 он хүртэл хэрэгжүүлэх шаардлагатай боловсролын 13 зорилтыг тодорхойлж, түүн дотор “идэвхитэй иргэн (active citizenship)”, эрх тэгш боломж, нийгмийн эв нэгдлийг дэмжих” тухай заасан².

Хүснэгт-1 “Лисбоны стратеги” дахь гурван гол стратеги ба зорилт

Европын холбооны боловсролын чанар, үр дүнг дээшлүүлэх	Боловсрол эзэмших боломжийг аль болох хялбар болгох	Дэлхийн боловсролын тогтолцоог чөлөөтэй болгох
- багш бэлтгэх тогтолцоог сайжруулах - мэдлэгт суурилсан нийгэмд шаардагдах үр чадварыг хөгжүүлэх - бүх хүмүүсийг ICT боловсрол эзэмших боломжоор хангах - шинжлэх ухаан болон технологи, судалгааны салбар дахь хүний нөөцийг нэмэгдүүлэх - эрдэс баялаг, түүхий эдийг зүй зохистой хэрэглэх	- Шинэ концепшил тулгуурлан судалгаа хийх (Opening learning) орчин - мэдлэг эзэмшүүлэх процессийг сонирхолтой болгох - идэвхитэй иргэний боловсрол (active citizenship), эрх тэгш боломж, нийгмийн эв нэгдлийг дэмжих	- ажил хөдөлмөр, судалгаа шинжилгээний ажил, нийгмийн харилцан уялдааг бэхжүүлэх - үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх сэтгэлгээг хөгжүүлэх - гадаад хэлний сургалтыг идэвхижүүлэх - шинэчлэлт, хамтын ажиллагааг өргөжүүлэх - Европын нэгдлийг бэхжүүлэх

Эдгээр боловсролын зорилго нь даяарчлагдсан нийгэмд нийгмийн эв нэгдлийг хангахын хамт “мэдлэгт суурилсан эдийн засаг” бүхий нийгмийн орчинд шаардлагатай хүний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн нь харагдаж байна.

Европын комисс (European Commission) “Боловсрол, дадлага 2010” (Education & Training 2010)-ын зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нэлээд ажлын баг бүрдүүлж, ардчилалыг хөгжүүлэхэд чиглэсэн “идэвхитэй иргэний боловсрол”-ын талаар олон удаа хурал зохион байгуулжээ. Улмаар “иргэний боловсрол нь аливаа хүн өөрийн амьдралыг өөрөө гардан бүтээн байгуулж, туршлага хуримтлуулахад чиглэсэн нийгмийн эв нэгдлийг хангах арга хэрэгсэл юм. Өөртөө хяналт тавьж, үүрэг хариуцлагаа ухамсарлах, бусадтай хамтран ажиллаж хөдөлмөрлөх, бүтээн байгуулалтанд суралцаж, түүнийг амьдралд хэрэгжүүлэх чадвар нь тогтворгүй байдал, эсвэл сөргөлдөөнийг сөрөн зогсох үед мэргэжлийн мэдлэг, хувь хүний үнэлэмж хөгжих боломжийг

олгодог” гэж тодорхойлсон байдаг³. Үүнээс үзэхэд хүндрэл бэрхшээлийг сөрөн давахуйц хувь хүний хөгжил, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэхэд хүмүүс хоорондын харилцаа, хамтын ажиллагаа чухлаар тавигдсан байна.

4. Жишиг үнэлгээ (benchmark) болон индекс

Энэ мэтчилэн Европын комисс ба Европын холбооны аль аль нь иргэний боловсролд анхаарал хандуулж ирсэн хэдий ч тэдний хандлага (approach) ялгаатай байдаг. Европын комисс нь улс орнуудад соён гэгээрүүлэх үйл ажиллагаа болон хамтын ажиллагааны сүлжээгээр дамжуулан “ардчилсан иргэний боловсрол”-ыг хэрэгжүүлэхийг зорьдог бол Европын холбоо нь Европын комиссын иргэний боловсролын үзэл санааг залгамжлан хүлээн авахдаа уг үзэл санааг улс орнуудад хэрхэн бодитой хэрэгжүүлснийг хэмжих баримжаа үзүүлэлт боловсруулсан байдаг.

Европын холбоо нь Лисбоны стратегийг хэрэгжүүлэхийн тулд “нээлтэй бодлого, хамтын ажиллагаа (Open Method of Coordination)” гэсэн бодлого хэрэгжүүлэх тогтолцоог нэвтрүүлсэн. Уг бодлогын хүрээнд Европын холбооны улс орнуудад нэгдсэн стратеги, удирдамж (guideline)-ийг тодорхойлж, улс орнууд түүнд нийцүүлэн өөрийн нөхцөл байдалтай уялдсан бодлогыг тусгайлан боловсруулж, нэгдсэн хэмжүүрт тулгуурлан хэрэгжилтэнд үнэлгээ өгөх болсон байна. Үүнтэй уялдан гишүүн орнуудад өгөгдсөн зорилгыг биелүүлэхэд санаачлага гаргаж ажиллахыг шаарддаг байна. Энэ зорилгын хүрээнд Лисбоны стратегийн нэгдсэн зорилгын хэрэгжилтийг хэмжих тулгуур мэдээлэл болгох тоон үзүүлэлт, жишиг үнэлгээ, индекс (үзүүлэлт)-ийг боловсруулж эхэлжээ. Тухайлбал нийт улс орнуудад хэрэгжүүлэх шаардлагатай дараах таван жишиг үнэлгээний үзүүлэлтийг боловсруулсан байна.

- Ямар нэгэн шалтгаанаар сургууль завсардсан сурагчдын тоог Европын хэмжээнд дунджаар 10 хувиас доош хэмжээнд барих

- Уншиж ойлгох чадвар бага 15 наснаас доош хүүхдүүдийг 2000 онтой харьцуулахад 20 хувиар багасгах

- Залуучуудын 85 хувийг бүрэн дунд шатны боловсролд хамруулах

- Тоо, шинжлэх ухаан, технологийн чиглэлээр магистр, докторантурын сургалтанд хамрагдах оюутны тоог 15 хувиар нэмэгдүүлэхийн зэрэгцээ жендерийн ялгааг багасгах

- Хөдөлмөрийн насны 25-64 насны хүн амын 12.5-аас дээш хувийг байнга боловсролоо дээшлүүлж байх нөхцлөөр хангах (насан туршийн боловсрол: lifelong learning-д хамруулах)

Дээрх үзүүлэлтээс харахад ерөнхий боловсролын сургуулиас эхлээд насанд хүрэгчдийн боловсрол хүртэлх боловсролын зорилго тоон үзүүлэлтээр тусгагдаж, суурь мэдлэг, боловсролын түвшинг дээшлүүлэх, ялангуяа технологийн чиглэлийн мэргэжилтэнг бэлтгэхийн зэрэгцээ насан туршдаа байнга боловсролоо дээшлүүлж байх нөхцлөөр хангаж суралцуулахад түлхүү анхаарчээ. Гишүүн орнууд уг зорилгыг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргах шаардлага тавьсан байна. Улмаар 2007 онд дор дурдсан 16 үзүүлэлтийг боловсруулж, түүнд иргэнд шаардагдах ур чадварын тухай тусгажээ.

**Хүснэгт-2 “Лисбоны стратеги”-ийн хэрэгжилтийг
хэмжих 16 үзүүлэлт**

Сургуулийн өмнөх боловсролд хамруулах	Залуучуудын бүрэн дунд шатны боловсролд хамрагдсан хувь
Тусгай эрэлт хэрэгцээтэй хүүхдүүдийн боловсрол	Багшлах боловсон хүчний мэргэжлийн боловсрол
Сургуулиас завсардсан хүмүүсийн үзүүлэлт	Их, дээд сургууль төгсөгчдийн тоо
Уншиж ойлгох чадвар, тоо, шинжлэх ухаан, бичиг үсэгт тайлагдсан байдал (Literacy)	Их, дээд сургууль дахь хил дамнасан оюулны шилжилт хөдөлгөөн (Mobility)
Гадаад хэлний мэдлэг	Насанд хүрэгчдийн насан туршийн боловсрол дахь оролцоо
ICT мэдлэг	Насанд хүрэгчдийн ур чадвар
Иргэний чадвар	Хүн амын боловсролын түвшин
Суралцах чадвар	Боловсрол дахь хөрөнгө оруулалт

Эх сурвалж: SEC “Commission staff working document” Progress toward the Lisbon objective in education and training. Indicators and benchmarks 2008

2006 онд Европын холбооны парламент болон Европын зөвлөлийн хурлын зөвлөмжинд “даяарчлал нь Европт шинэ сорилтыг авчирсан юм. Харилцан уялдаатайгаар идэвхитэй өөрчлөгдөх нийгэмд уян хатан зохицоход түлхүүр чадвар (key competency) хэрэгтэй”⁴ гэж үзэн “насан туршийн боловсролын түлхүүр чадвар”-ыг тодорхойлсон байдаг. Үүнд эзэмших шаардлагатай найман чадварт “иргэний чадвар” (civic competences) орсон байдаг. Үүнийг дор дурдая.

- эх хэлээрээ бусадтай харилцах чадвар
- гадаад хэлээр бусадтай харилцах чадвар
- тоо, шинжлэх ухаан, технологийн суурь мэдлэг
- тоон технологийн чадвар
- суралцах ур чадвар
- хүмүүс, соёлын хоорондын харилцаа, нийгмийн харилцаа, иргэний чадвар
- идэвхи санаачлага (Initiative), үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх сэтгэлгээ
- соёлын тухай мэдлэг, ойлголт (awareness) болон илэрхийлэх чадвар

Үүнээс насан туршийн боловсрол нь боловсролын тулгамдсан болон хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэхийн зэрэгцээ хүмүүнлэг, ардчилалын үнэт зүйл болон эрх тэгш зарчимд суурилсан, боловсролын бүхий л хэлбэрийг хамарсан, мэдлэгт суурилсан нийгмийн салшгүй хэсэг болох нь харагдаж байна. Мөн гадаад хэлний чадвар болон ICT, гадны соёлыг ойлгох чадвар зэрэг нь даяарчлагдсан нийгэмд зохицсон иргэнийг бэлтгэхэд чухлаар тавигджээ. Энд дурдагдах Европын холбооны улсуудад зорилго болгон тавигдсан “иргэний чадвар” гэдэг нь юу вэ. Европын холбоо нь Европын комиссын үзэл санааг уламжлан авч, иргэний чадамжийг мэдлэг, ур чадвар, үзэл бодол, үнэт зүйл (үнэлэмж), үйл хэрэг гэсэн таван өнцгөөс цогцоор авч үзсэн байдаг. Мэдлэгийн хувьд сургуулийн

олон талт соёл, улс төрийн тухай нийтлэл (issue) зэргийг гаргаж дэвшүүлэх зэргээр мэдлэгийг сурагчдын амьдралтай холбосон нь анхаарал татдаг. Түүнчлэн бусдын ялгаатай орчин, соёл, үзэл бодлыг ойлгож хүлээн аван, бусадтай эвлэлдэн нэгдэж, нийгмийн бүлэг, харилцаанд идэвхитэй оролцох чадвар эзэмшүүлэх зорилго агуулсан байна.

Хүснэгт-3 Иргэний чадвар

Мэдлэг	Улс төр болон хууль зүйн тогтолцооны үндсэн хүчин зүйл (бүс нутаг, улс орон, Европын холбооны хэмжээн дэх хүний эрх, иргэний эрх, үүрэг, Парламент, Засгийн газар, санал өгөх гэт), хэвлэл мэдээллийн хэрэгслийн үүрэг роль, сургууль болон улс орон доторх олон талт соёл, сайн дурын олон нийтийн байгууллагын үйл ажиллагаа, улс төрийн хэвлэн нийтлэл гэх мэт
Ур чадвар	Санал бодол болон бодит байдлыг ялгаж салгах, аливаа сөргөлдөөнийг энх тайванч зарчимд тулгуурлан шийдвэрлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах мэдээллийн утга санааг ойлгож тайлбарлах, үзэл бодлоо илэрхийлэх, улсын бодлого, шийдвэрийг хянаж (monitor), нөлөө үзүүлэх, бусадтай хамтран ажиллах (interaction), олон талт соёлын орчинд ажиллаж амьдрах гэх мэт
Үзэл бодол	Шийдвэр болон үйл хэрэгтээ хариуцлагатай хандах, өөрийн итгэл үнэмшилтэй улс төрд оролцох, ардчилалын чиг үүрэг, ялгаатай байр суурь, үзэл бодол, харилшан буулт хийх, ил тодоор хандах гэх мэт
Үнэлэмж	Хууль журмыг дагаж мөрдөх, нийгмийн шударга ёс, иргэдийн эрх тэгш зарчмыг дээдлэх, жендер болон шашин шүтлэгийг хүндэтгэх, хэт явцуу үзэл, арьс өнгөөр ялгаварлах үзэл, бусдыг ялгаварлан гадуурхахын эсрэг байх, хувь хүний бахархал (dignity), эрх чөлөөг хүндэтгэх, ардчилсан үзлийг дээдлэх, байгаль орчинг хамгаалах
Үйл хэрэг	Улс төрийн бүлэг, нийгмийн бүлэг, иргэний нийгэмд идэвхитэй оролцох

Эх сурвалж: SEC “Commission staff working document” Progress toward the Lisbon objective in education and training. Indicators and benchmarks 2008

Лисбоны стратегид тулгуурласан дээрх боловсролын зорилгын хэрэгжилтийг үнэлэхийн тулд түүний үзүүлэлт, зорилго тодорхойлогдох явцад 2005 онд Хамтын судалгааны хүрээлэн (Joint Research Center)-д насан туршийн боловсролын төв (Center for Research on Lifelong Learning) байгуулагдаж, боловсролын үзүүлэлт (indicator)-ийг боловсруулж, үнэлгээ өгөх болсон. Уг төвд “идэвхитэй иргэн (active citizenship)” болон иргэний чадварын үзүүлэлтийг боловсруулж байна. Тус төвөөс идэвхитэй иргэний боловсролыг “хүний эрх, ардчилсан үзэлд тулгуурласан харилшан хүндлэх, иргэний нийгэм болон нийгмийн бүлэглэл, улс төрийн амьдрал (political life) хүч хэрэглэлгүй оролцохыг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг⁵. Өөрөөр хэлбэл идэвхитэй иргэний боловсролд улс төр, нийгмийн бүлэглэлд хүмүүс ямар түвшинд оролцдог вэ гэдэг нь анхаарал татсан асуудал болдог байна. Иймд идэвхитэй иргэний боловсролын үзүүлэлтийг сонгуульд санал өгөх зэргээр “иргэний ардчилсан нийгэмд оролцох”, байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд оролцох, тодорхой нэг бараа бүтээгдэхүүнийг худалдан авахыг эсэргүүцэх (boycott) зэргээр “эсэргүүцлээ илэрхийлж (protest) нийгмийг өөрчлөх”, нийгмийн бүлэглэлд эвлэлдэн

нэгдэх зэргээр “нийгмийн бүлэглэлд оролцох” гэсэн гурван хэсэгт хуваан үзжээ. Улмаар ардчилсан үзэл болон хүний эрх, гадны орны соёлыг ойлгож хүлээж авах чадвар зэргийг харуулсан “ардчилсан үнэ цэнэт зүйл”-ийг оруулаад нийтдээ 61 үзүүлэлт боловсруулсан байдаг. Эдгээр үзүүлэлтээс шинээр урган гарч ирсэн асуудал нь “идэвхитэй иргэн”-ийг төлөвшүүлэхийн тулд ямар боловсрол хэрэгжүүлэх шаардлагатай вэ гэсэн асуудал юм. Иймд боловсролын “гарц” болох хувь хүний мэдлэг болон чадвар, үзэл бодол, үнэлэмж зэрэг “идэвхитэй иргэн”-ийг сургаж төлөвшүүлэхэд шаардлагатай ур чадварыг хэмжих үзүүлэлтийг боловсруулжээ. Үүнд дээр дурдсанчлан “иргэний чадвар”-ыг мэдлэг, чадвар, үзэл бодол, үнэлэмж, үйл хэрэг гэсэн таван өнцгөөс цогц байдлаар авч үзжээ. Үүнээс үзвэл “иргэний чадвар”-т тухайн хувь хүний нийгэм болон гэр бүлийн орчин, боловсролын байдал нөлөөлдөг, эдгээр туршлага, боловсрол зэрэг “орц”-ын нөлөөгөөр бий болох “гарц” нь хувь хүний чадвар юм. Иймд “идэвхитэй иргэн” нь нийгмийн “гарц” болдог байна. Уг төвийн судалгааны давуу тал нь хувь хүний иргэний чадвар болон “идэвхитэй иргэн”-ий харилцааг үнэлэх үзүүлэлтийг тодорхой боловсруулсанд оршиж байгаа юм. Эдгээр үзүүлэлтийг боловсронгуй болгох судалгаа цаашид хийгдсээр байх юм.

5. Төгсгөлийн онрид

Уг сэдэвт Европ дахь иргэний боловсролд хамаарах Лисбоны стратеги болон түүний хэрэгжилтийг хэмжих үзүүлэлтийг хэрхэн боловсруулсан талаар, мөн “иргэний чадвар”-ыг хөгжүүлэхэд чиглэсэн “идэвхитэй иргэний боловсрол”-ыг хэрэгжүүлэхээр зорьж буй талаар танилцууллаа. Үүний цаана “мэдлэгт суурилсан эдийн засаг” бүхий даяарчлагдсан нийгэмд ажиллаж, амьдрах хувь хүнийг хөгжүүлэхийн зэрэгцээ улс төр, нийгмийн үйл хэрэгт идэвхи, санаачлагатай оролцож, бусад хүмүүстэй хамтран хөдөлмөрлөхөд суралцан, улмаар нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах “идэвхитэй иргэн”-ий тухай ойлголт чухлаар тавигджээ. Уг “идэвхитэй иргэн”-ий чадвар болон түүнийг үнэлэх хэмжүүр нь тухайн улс орны нөхцөл байдлаас хамааран ялгаатай тул нэгдсэн хэмжүүр гаргах асуудал тийм ч амаргүй юм. Гэхдээ нийтлэг үзүүлэлт, хэмжүүр боловсруулах эхний алхмууд аль хэдийн эхэлжээ.

Бид дээрх туршлагаас иргэний чадварыг мэдлэг, чадвар, үзэл бодол, үнэлэмж, үйл хэрэг гэж цогц байдлаар авч үзсэнийг анхаарах хэрэгтэй юм. Мөн иргэний боловсролын “гарц” болох иргэний чадварыг үнэлэх хэмжүүр гаргах оролдлого хийгдсэн нь бидэнд сургамж болох юм. Манай улсад ихэнхи тохиолдолд иргэний боловсролын агуулга нь төрийн удирдлага, хууль ёсыг сурталчлах чиг хандлагатай байдаг. Мөн боловсролын бүхий л шатанд иргэний боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг хомс, нийгмийн харилцаанд зөв оролцох, зөв итгэл, үнэмшил, үнэлэмж төлөвшүүлэхэд чиглэсэн заах арга зүйн талаарх хичээл судлалын тогтолцоо, эрдэм шинжилгээний ажил хангалтгүй байдаг. Бид цаашид иргэний боловсролын сургалтын чанарыг сайжруулахад удирдамж болохуйц судалгааг олон улсын хэмжээнд харьцуулж, өөрийн

орны түвшинд иргэнд боловсролоор олгох мэдлэг, чадвар гэж юу болох, түүнийг хэрхэн үнэлэх зэргийг тодорхойлж, иргэдийнхээ мэдлэг боловсролын түвшин, нийгмийн орчин, сургалтын хөтөлбөр зэрэгтэй уялдуулсан иргэний боловсролын үндэсний хэмжээний хөтөлбөр боловсруулах шаардлагатай. Үүнд иргэний боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн болон эрдэм шинжилгээний байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх, хамтран ажиллах тогтолцоог боловсруулах нь нэн чухал юм.

Эшлэл:

1. Durr, Karlheinz et al. (2000) Project on “Education for democratic Citizenship Strategies for learning Democratic Citizenship”, “Strasbourg; Council of Europe Publishing, pp.13-14
2. European Commission (2003) Implementation of “Education Training 2010” Work Programme. Working Group “Open Learning Environment, Active Citizenship and Social Inclusion” Progress Report. p.4
3. Weerd, Marga.et al. (2005) Indicators for monitoring active citizenship and citizenship education-final report, Amsterdam; Regioplan publication number; 126ld,p.10
4. Hoslins, Bryony et al. (2006), CRELL research paper 4; measuring active citizenship in Europe, Ispra; CRELL,p.10
5. SEC “Commission staff working document” Progress toward the Lisbon objective in education and training. Indicators and benchmarks 2008, Brussels

Ном зүй:

1. Council of Europe (2005) “European year of citizenship through education 2005- learning and living democracy-” Concept paper, 2004, Strasbourg
2. Durr, Karlheinz et al. (2000) Project on “Education for democratic Citizenship Strategies for learning Democratic Citizenship”, “Strasbourg; Council of Europe Publishing
3. European Commission (2003) Implementation of “Education Training 2010” Work Programme. Working Group “Open Learning Environment, Active Citizenship and Social Inclusion” Progress Report
4. Сонояама Дайсүкэ “Европыг нэгтгэхэд чиглэсэн боловсролын бодлогын өнөөгийн байдал болон хэрэгжилт” Ойта их сургуулийн боловсрол, нийгмийн халамжийн факультетийн харьяа Боловсролын практик төвийн 24 дүгээр эмхэтгэл, 2006 он
5. Минэй Акико “Дэлхийн иргэний боловсрол” Тошиндо хэвлэлийн компани, 2007 он
6. Накаяама Аой “Европын иргэний боловсрол” Осакагийн боловсролын их сургуулийн 58 дугаар эмхэтгэл, 2010 он